

МОНГОЛ ӨРХ 2020 ХӨГЖЛИЙН БОДЛОГО
УВС АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

/ 5 бүлэг 229 зүйл /

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ



1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

- Бүс нутгийн хэмжээний багтаамж бүхий үйлдвэрлэлийн мэргэжилтэнг бэлтгэх чиглэлээр МСҮТ-ийн сургалтын чиглэлийг шинэчлэн тогтоож, инженер техникийн мэргэжилтэнг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдийг аймагтаа сургаж бэлтгэдэг тогтолцоог бий болгоно.
- Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг инновацид тулгуурласан шинэ технологи нутагшуулахад чиглүүлнэ
- Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн сурах орчныг олон улсын шаардлагад нийцүүлэн боловсролын чанарын ялгааг арилгана.
- Боловсролын барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шат бүхий хэрэгсэл суулгана.
- Ард иргэдэд цахим боловсролыг олгох /Digital Literacy/ насан туршийн боловсролын төвийг сум бүрд байгуулна.
- Сургуулийн дотуур байрны орны тоог нэмэгдүүлж, сургуулийн орчинд интернетийн өргөн сүлжээ байгуулан, цахим сургууль хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Монголын уламжлалт соёл, зан заншил, улс орныхоо байгаль түүх үндэсний хэл уламжлалаараа бахархдаг “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрөө үргэлжлүүлнэ.
- Хүүхэд багачуудыг төрсөн нутаг усаараа бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулан суурь боловсрол эзэмших хугацаанд нь аймагтайгаа бүрэн танилцах “Цэнхэр тэнгэрийн орон” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Багш хөгжлийн төв байгуулах замаар орон нутагт багш нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх сургалтын “Шинэ багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Аймгийнхаа бүх цэцэрлэг сургууль, дотуур байрыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг ажил олгогчдын гэрээ, захиалгад тулгуурлан сургах, ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлнэ
- Багийн төвүүдийг түшиглэн зайны сургалтын төвүүдийг байгуулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа багшлах боловсон хүчин, ахмад багш нартай хамтран малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ

1.2 Эрүүл мэндийн төгс үйлчилгээ

- Увс аймгийн НЭ-ийн оношлогооны тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж азийн орнуудын хэмжээнд хүргэнэ.
- Эрүүл мэндийн салбарт социал медиа маркетинг нэвтрүүлнэ.
- “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлж 6-17 насны хүүхдийг оношлох, эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. /шүд,нүд,чих хамар хоолой,дотор/
- Сум бүрт зайн оношлогоо, явуулын үйлчилгээний одоогийн байдлыг үнэлж, нэгдсэн сүлжээг бий болгох, эмнэлэгийн тоног төхөөрөмж, мэдээлэл технологи, техникийн ажилтны орон тоог бий болгон хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Сумдын эмч, мэргэжилтэнд орчин үеийн хиймэл оюун ухаанд суурилсан эмчилгээний дэвшилтэт технологи эзэмшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна
- Нэн шаардлагатай мэргэжлээр мэргэшүүлэх, давтан сургах эмч нарын хэрэгцээг үндэслэн алслагдсан нутгийн хүн амд үзүүлэх нарийн мэргэжлийн эмнэлэгийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад харилцааг өргөжүүлж эмч, мэргэжилтэнг гадаад, дотоодод сургах, тэдний гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх аймгийн хөтөлбөр үргэлжлүүлнэ.
- Сувилагч үндэсний хөтөлбөрт орон нутгийн сувилагчдаа хамруулан сургахад аймгаас дэмжлэг үзүүлэх боломжийг судална.
- Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, мэргэжилтэнг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах нөхцөл боломжийг судлаж ажиллана.
- Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн урлог андорлогийн кабинетийг нээж хэвтэн эмчлүүлэх тасгийг бие даалган байгуулна.
- Баруунтуруун, Өндөрхангай, Өмнөговийн сум дундын эмнэлгийг сэхээн амьдруулах, мэдээгүйжүүлэлт шаардлагатай мэргэжлийн эмчээр хангах, сум дундын эмнэлэгийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- Сум дундын эмнэлэг болон сум, өрхийн эрүүл мэндийн төвд өөрийн санаачилгаар ажиллаж байгаа шинэ төгсөгч нарыг орон сууцны хөнгөлттэй зээлд хамруулах боломжийг судална.
- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн залуу эмч нарын мэргэжил боловсролыг хуулийн дагуу 5 жил тутамд тасралтгүй дээшлүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- Өрхийн эмнэлэгт түшиглэсэн гэрийн эмч хөтөлбөр хэрэгжүүлэн иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд бүрэн хамруулна.
- Зарим сум, сургуулийг шүдний эмчийн кабинеттэй болгож тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, эмч мэргэжилтэнг сургаж дадлагажуулна.
- Хүн ам төвлөрсөн баг бүрт иргэдэд зориулсан чийрэгжүүлэлт, биеийн тамирын задгай талбай байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ

- Төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн оношлогооны төвүүдийг байгуулахыг орон нутгаас дэмжнэ.
- Сумын эмнэлэгийн лабораторийн дэвшилтэт технологи, шинжилгээний төрлийг нэмэгдүүлж хүртээмжийг сайжруулна.
- Хорт хавдрын оношилгоо, хавдар хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх нэгжийг аймагтаа барьж байгуулан орчин үеийн тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангана.
- Орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, эмчилгээ хяналтын комиссын тайланд үнэлгээ дүгнэлт хийж аймгийн иргэдэд зонхилон тохиолдох өвчлөлийн эсрэг урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Аймгийн хэмжээнд байгаа ус, рашааныг түшиглэсэн амралт сувилалын газар байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэн эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг амралт сувилалын газартай болно./Хар тэрмэс, Урт булаг, Гивант, Цагаанхайрхан.. гэх мэт/
- Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлэгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөнө.
- Эхнэлхасын эндэгдлийг тогтвортой бууруулах НҮЭМ-ийн цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

1.3 Хүн амын хөгжил

- Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн болон эрүүл мэндийн боловсрол олгох “Жаргалтай өрх” орон нутгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь төр иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хүрээнд тус үйлчилгээг аймагтаа сэргээн хэрэгжүүлнэ.
- Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т “...газрын хэвлийн баялагийн үр өгөөжийг Үндэсний баялагийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ.” гэсний дагуу Увс аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нүүрсний болон бусад уурхайтай хамтран зорилтот бүлэгт чиглэсэн өрхийг дэмжсэн аймгийн бодлоготой болно.
- 2012-2016 онд хэрэгжүүлсэн орон сууцжуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэх замаар барилгын компаниудад газар дэд бүтцийн дэмжлэгийг үзүүлнэ.
- Түрээсийн байр аймгийн хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж зорилтот бүлгийг хамруулна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах ажлыг сайжруулна.
- Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах аймгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн “Хөх толбот” хадгаламжаа үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- Жендерт суурилсан хүчирхийлэл ялгаварлан гадуурхал ,бэлгийн дарамтыг арилгах санаачлага,манлайллыг дэмжинэ.
- Хүн амаа эрүүл аюулгүй хүнсээр хангах хяналтын тогтолцоог бүрдүүлнэ
- Олон улсын даатгалын сүлжээ бүхий хувийн болон давхар даатгалын үйлчилгээг аймагтаа нээнэ.
- Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан аймгийн хүний нөөцийн бодлоготой болно.
- Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж,ажилгүйдлийг бууруулах чиглэлээр Сум хөгжүүлэх,Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн орлогыг олон эх үүсвэрээс бүрдүүлж нээлттэй ил тод сонгон шалгаруулалт санхүүжилт,тайлагналтын тогтолцоог бий болгоно.
- Гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх аймгийн бодлогод хяналт үнэлгээ хийж үйл ажиллагааг залуучуудын бизнесийг дэмжихэд чиглүүлнэ.
- Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн бодлогыг нэн шаардлагатай өрхөд иргэдийн хяналттай олгодог аймгийн журам гаргаж хэрэгжүүлнэ
- Ахмадын хөгжлийн төвийг сум бүрт байгуулж ажиллуулна.
- Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг дэмжих ,урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Малчин,хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалыг хамралтыг нэмэгдүүлж тэдний нийгмийн баталгааг хангах мэдээлэл сурталчилгааны ажлыг сайжруулна.

1.4 Соёл урлаг спорт

- Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах,сэргээн засварлах,түүнийг хамгаалан цуглуулагч,тээн уламжлагч нарыг аймгаас бүх талаар дэмжинэ
- Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын Увс аймгийн бүртгэлийн санг шинэчлэн гаргаж хамгаалалтын тогтолцоог бүрдүүлнэ
- Ойрад театр,сумдын соёлын байгууллагуудын бие даасан байдлыг хангаж олсон орлогоо өөрөө захиран зарцуулах санхүүгийн эрх олгох
- Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын болон олон улсын түвшинд гаргахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- Улсын болон орон нутгийн төсвөөс Увс аймгийн уламжлалт болон дэлхийн сонгодог бүтээлийг нийтийн хүртээл болгох бодлого боловсруулж ажиллана.
- Спортын олон улсын хэмжээний арга хэмжээ,уралдаан тэмцээнийг аймгийн онцлогтой уялдуулж тогтмолжуулна.
- Аймгийн бага Олимпийг 2 жил тутамд зохион байгуулна.
- Сумын ард иргэд хүүхэд залуучуудыг спортоор хичээллэх чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спорт заалны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Зүүнговь сумыг түшиглэн стандартын шаардлагад нийцсэн цанын олон төрөлтийн элсний авторалли , дугуйн спорт хосолсон олон улсын байгууллагын дэмжлэгтэй байгуулна.
- Хичээлийн болон дотуур байрны нөөц бүхий зарим сум,багийн сургуулиудыг түшиглэн спортын иж бүрэн цогцолбор бүхий төрөлжсөн сургуулиудыг байгуулна
- Биеийн тамир спортын хуулийн дагуу сум бүрт биеийн тамирын арга зүйчийг томилон ажиллуулна.
- Олимпын олон төрлөөр өсвөр залуучууд ,насанд хүрэгчдийн аймаг бүсийн тэмцээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Эрүүл идэвхтэй аж төрөх талаар олон нийтэд ойлголт өгөх сургалт сурталчилгаа хөдөлгөөн ,клубийн үйл ажиллагааг дэмжинэ.
- Их спортыг дэмжин спорт холбоодыг амжилтаар нь дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1 Өсөлтийн бодлого

- Ажиллах хүчийг нэмэгдүүлэх , ядуурлыг бууруулах , 100 мянган шинэ ажлын байр бий болгох хөтөлбөрийн хүрээнд бүтээн байгуулалт бизнесийн төслүүдийг аймгийн онцлогт тохируулан хэрэгжүүлнэ
- Баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ЖДҮ-ийн сангаас санхүүжүүлдэг болгоно.
- Бүртгэл,гааль,татвар,хяналт лавлагаа мэдээлэл,худалдан авах ажиллагаа зэрэг үйлчилгээг бүрэн цахимжуулна.
- Өмчийн эрхийг баталгаажуулж,хувийн өмчийг бүх талаар хамгаална.
- Увс аймгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны сангуудтай хамтран ажиллана.
- Эдийн засгийн түншлэл чөлөөт худалдааны хэлэлцээрүүд,олон улсын хамтын ажиллагааны хүрээнд “Улаангом “ чөлөөт бүсийг байгуулах
- Бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал дарамтыг арилгаж,татвар төлөгч аж ахуйн нэгжүүддээ үйлчилдэг,зөвлөдөг тогтолцоог аймагтаа бүрдүүлнэ.
- Хуучин хүнсний захыг тохижуулах,стандарт эрүүл ахуйн шаардлага хангуулахад дэмжлэг үзүүлнэ
- ЖДҮ эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, зах зээлийн судалгаа хийж өгөх зэрэг бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.
- Төсвийн зардлыг ач холбогдол үр өгөөжөөр нь эрэмбэлэх, үр ашигтай хувиарлалтын бодлого хэрэгжүүлнэ
- Төсвийг судалгаанд суурилсан төлөвлөлт,сахилга хэрэгжилт хяналтыг хангах оновчтой системээр удирдан чиглүүлнэ
- Боршоо, Шар суурь боомтын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутагт үйлдвэрлэх түүхий эдийн нөөцгүй бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг хөнгөлөх замаар өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдлийг хязгаарлах

- Тендэр, төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавих иргэдийн зөвлөлийг ажиллуулж олон нийтэд ил тод нээлттэй болгож, цахим мэдээллийн санд байршуулна
- Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх иж бүрэн төвүүдийн тоог олшруулах
- Шатахуун тослох материалын бүсийн ялгаваргүй нэг үнийн сиситемтэй болгоно.
- Иргэдийн газар өмчлөлийг бүрэн шийдэж, газрыг нь эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.
- Увс аймагт улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн Шүдэн уулын давс, Хүдэнгийн уурхай, Хотгорын нүүрсны сав, Хар тарвагатай, Харганат, Сагилын гөлтгөнө, Цагаанчулуутын шохойн ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын жагсаалтанд оруулах замаар орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхболомжийг судалж шийдвэрлэнэ.
- Ан амьтан агнах тусгай зөвшөөрөл олголтыг оновчтой болгож хувиарлалтыг орон нутагт шилжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- Эрдэс баялгийн ,малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байраар хангана

2.2Төрөлжилтийн бодлого

2.2.1Үйлдвэрлэлийн салбар

- Нэмүү өртөг шингээх эх орны органик хүнсний бүтээгдэхүүн жимс жимсгэний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх замаар хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ.
- Иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачлагыг бүх талаар дэмжинэ.
- Мах боловсруулах, арьс шир, ноолуур угаах үйлдвэр байгуулна.
- Увс аймгийн хэмжээнд усны судалгаа хийнэ.
- Увс усжуулалт аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэнЗүүнтуруун, Түргэн-Хавцал, Хяргас-Хангилцаг, Зүүнговь-Харбураа, Малчин-Улаанбулаг, Улаангом-Арсайн,Өмнөговь-Орлого, Давст-Торхилог, Сагил-Сэнжийн тариг, Өлгий Шивээн гол, Тэсийн услалтын системийг байгуулах, сэргээх замаар үр тариа, тэжээлийн ургамал тариалалтыг төрөөс дэмжих, Наранбулаг-Тээлийн боом, Тариалан, Баруунтуруун суманд тэжээлийн үйлдвэр байгуулна
- Үр тарианы үйлдвэрлэлийг дэмжих Гурилын үйлдвэрийг Баруунтуруун сумыг түшиглэн байгуулах санал санаачлагыг бодлогоор дэмжинэ.
- Хүнсний ногоо боловсруулах бүс нутгийн хэмжээний томоохон үйлдвэрийг байгуулна
- Аймгийн төвд нүүрсний нөөцдөө тулгуурласан шахмал түлшний үйлдвэр байгуулан бүсийн аймгуудын түлшний хэрэгцээг хангана
- Аймгийн нутаг дэвсгэрт байгаа төмрийн ордуудыг төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх замаар хүдэр баяжуулах, төмөр боловсруулах үйлдвэр байгуулах нөхцлийг бүрдүүлнэ.

- Сургууль цэцэрлэгийн үдийн хоол хөтөлбөрт сүү, сүүн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх аймгийн бодлого гарган хэрэгжүүлэх замаар сүү,сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ
- Зайнаас ажиллах боломжтой иргэд,залуучуудад зориулсан цахим мэдээллийн төвийг байгуулж, 10000ажлын байр бий болгох хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх
- Мал, махбэлтгэлийннэгдсэнтотголцоогбийболгох "Махтаръя" хөтөлбөрхэрэгжүүлэхзамаармалнядлах, ангилансавлах,консервлэхүйлдвэрийг Улаангом хотодбайгуулжмахтээвэрлэх, борлуулахсүлжээгөргөтгөн ОХУ-д мах, консервалсанбүтээгдэхүүннийлүүлэхзамаармалчдынорлогыгтогтвортойнэмэгдүүлнэ.
- Чацарганаболовсруулахбүсийнхэмжээнийүйлдвэрийгтөр, хувийнхэвшлийнтүншлэлийнхүрээндхөнгөлөлтэйзээлээрдэмжижУлаангомхотод байгуулна.

2.2.2 Эрдэс баялгийн салбар

- Төрийн нийтийн зориулалттай зарим өмч /газар,газрын хэвлий,ус ой/ тэдгээрийн дагалдах болон дагалдах баялгийг орон нутгийн хамгаалалтанд авах замаар иргэн хуулийн этгээдэд эзэмшүүлэх ашиглуулах журмыг хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Аймгийн хэмжээнд хөндөгдсөн газрын тооллого судалгааг нарийвчлан гаргаж орон нутгийн мэдэлд авах замаар хувиараа эрдэс баялаг үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг бүлэг нөхөрлөлийн хүрээнд дэмжин ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж байгаль орчныг нөхөн сэргээнэ.

2.2.3 Дэд бүтэц

- Улаангом-Цагаануурын чөлөөт бүсийг холбосон хатуу хучилттай замыг байгуулах
- Увс аймгийн аялал жуулчлалын үндсэн маршрутын дагуу жуулчны бааз байгуулах дэд бүтцийг бий болгоно .
- Улаангом-Увс нуур чиглэлийн хатуу хучилттай замыг барьж ашиглалтанд оруулна
- Улаангом-Баруунтуруун, Улаангом-Ховд чиглэлийн хатуу хучилттай замыг барьж ашиглалтанд оруулна.
- Хилийн боомтуудыг хатуу хучилттай хямд өртөгтэй авто замаар холбоно
- Баруунтуруун сумын агаарын тээврийн үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх замаар зүүн бүсийн сумдын иргэдийн зорчих нөхцлийг хөнгөвчилнө.
- Сумдын цахилгаан шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлж, шугам сүлжээг өргөтгөх, Улаангом сумын үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийг байгуулна.
- Баруунтуруун, Тариалан зэрэг газар тариалангийн бүс нутгуудад газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг бий болгож, газар тариалан эрхлэгчдэд үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бага хүүтэй зээлийн дэмжлэг үзүүлнэ

- Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэж ,аймаг сумын төвийн усан хангамжийнчанар хүртээмжийг сайжруулна
- Цахилгааны эх үүсвэрт холбогдсон бүх худгийг ухаалаг болгоно.
- Сумын төв суурин газруудыг хяналтын камерийн системтэй болгоно.
- Хог боловсруулах үйлдвэр байгуулах, хур хогийг цэвэрлэх, хогийн цэгт биологийн нөхөн сэргээлт хийх төсөл хэрэгжүүлнэ
- Төв суурин газрын хог тээврийн хадгалалт тээвэрлэлтийн менежментийг сайжруулан төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Хот суурин газрын ногоон байгууламжийг иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан үйлчилгээг худалдах авах тогтолцоог бүрдүүлэх
- Улаангомоос Тэс явах замын элстэй хэсгийг сайжруулах
- Сумын нэгдсэн халаалтын зуухны хүчин чадал нэмэгдүүлэх замаар сумын төвийн өрхүүдийг инженерийн шугаманд холбох
- Орон нутгийн чанартай зам даваа, голын гүүр даланг барьж байгуулна.
- Тува,Улаангом,Ховд Жаргалант,Ярантай,Шинжаан чиглэлийн тээвэр логистик байгуулах
- Улаангом сумын инженерийн шугам сүлжээг өргөтгөх ажлыг үргэлжлүүлнэ
- Улаангом -Тариалан сумыг холбосон хатуу зам барьж байгуулна.
- Сумын төвийн ААН, албан газар, гэр хороололыг инженерийн шугам сүлжээгээр холбоно.
- Улаангом сум доторх хатуу хучилттай авто болон дугуйн замын өргөтгөн бүх багуудыг холбосон сүлжээг байгуулна.
- Аймгийн газар эзэмшил, өмчлөлийн байдалд хяналт үнэлгээ хийж замаар газар ашиглалтын аймгийн бодлогод шинэчлэлт хийж, хот төлөвлөлттэй зохицуулах шинэтгэл хийнэ.
- Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд Улаангом сумыг улсын зэрэглэлтэй хот болгон хөгжүүлнэ
- Хотын дэд бүтцийг байгуулахдаа ХБИ-дэд ээлтэй байхаар барьж байгуулна
- Улаангом сумын гэр хорооллуудын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлыг технологийн нөөцөд нь тулгуурлан шинэчилнэ.

2.2.4 Эрчим хүч

- Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангана.
- Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийг ухаалаг тоолууртай болгож эрчим хүчний хэрэглээг дэмжинэ.
- Аймгийн төв болон сумдын гэр хороолол гудамж талбайн гэрэлтүүлгийг өргөтгөж менежментийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- Сумдын төвийн шинэ суурьшлийн бүсэд цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татажөргөтгөнө.

- Цахилгаан дамжуулах шугаманд хямд зардлаар холбогдох боломжтой бүс нутгийн жагсаалт гаргаж цахилгаан дамжуулах ажлыг эхлүүлнэ.

2.2.5 Шинжлэх ухаан технологи,мэдээлэл харилцаа холбоо

- Газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулж, технологи дамжуулах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ
- Иргэдэд зориулсан цахим боловсролын төвийг төрийн байгууллага сум бүрд байгуулна.
- Шууданг сум багт хүргэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, электрон шуудангийн сүлжээг нэвтрүүлэх,орон сууц бүрт шуудангийн хайрцаг байгуулах шинэлэг ажлыг хийж эхлэнэ.

2.2.6 Барилгын салбар

- Ипотекийн “Найман хувь” хөтөлбөрийг сэргээж хүүг бууруулна.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэх замаар агаар хөрсний бохирдлыг бууруулна.
- Орон нутгийн хот суурины дахин төлөвлөлтийн хүрээнд хуучин барилга байгууламжийг дахин төлөвлөн барилгажуулахад татварын хөнгөлөлт үзүүлнэ.
- Сумдад нэн шаардлагатай боловсрол соёл,эрүүл мэнд төрийн захиргааны барилга байгууламжийг шинээр барих,засварлах аймгийн жагсаалт гарган эрэмблэж үе шаттай хэрэгжүүлэх
- Увс аймагтбарилгынматериалынүйлдвэрлэлийгхөгжүүлэхэдтусгайландэмжлэгүзүүлэх замаарзорилтотбүлгийнхэрэгцээндсуурилсан “Оронсууц” хөтөлбөрийгхэрэгжүүлнэ.

2.2.7 Аялал жуулчлал

- Спортын, эрүүл мэндийн,эко-туризмын ,нүүдэлчний өв соёлоо сурталчлах зэрэг аялал жуулчлалыг дэмжин хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн иргэд ,олон нийтийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалт хийхийг дэмжинэ.
- Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний үр чадварыг хөгжүүлнэ.
- 800 мянган жуулчин авах үндэсний хөтөлбөрийн хүрээндУвс аймаг ОХУ-ын 8000 жуулчин, бусадорны 4000, дотоодын 30000 жуулчингжилдээхүлээнавахбизнестөслүүдийгдэмжинхэрэгжүүлнэ.
- Сумыниргэдийнболонжуулчдынцагхугацаахэмнэсэн, аятахтайаюулгүйдотоодынагаарынтээврийн үйлчилгээгсумдадявуулах

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- Увс аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбараа тодорхойлж, бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан хамтран хөгжих дэд бүтэц, барилга байгууламж, тээвэр логистикийн сүлжээг бий болгоно.
- Хөрш зэргэлдээ ОХУ-тай хийх худалдааны таатай нөхцөл хил гаалийн боомт, дэд бүтцийг бүрдүүлж харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжинэ.
- ОНХСанг зөвхөн төсвийн хөрөнгөөр бүс олон хэлбэрт эх үүсвэрээс бүрдүүлэн захиран зарцуулах үр ашигтай хэмнэлттэй хяналтын тогтолцоог бий болгоно.
- Хуулиар олгогдсон санхүүгийн эрх мэдлийн хүрээнд хөгжлийн бонд, хөрөнгө оруулалтын сан байгуулах замаар аймгийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлнэ.
- “Инновацийн сан”-ийн хуулийн хүрээнд мал аж ахуй, газар тариалан, гахай тахиа, загас, зөгий, жимс жимсгэний аж ахуйд суурилсан шинэ брэнд бүтээгдэхүүний бизнесийг орон нутгаас дэмжинэ.
- Малаж ахуйн гаралтай түүхий эд ноос ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тордолт хийх сүлжээ агуулахыг бүсчлэн байгуулна.
- Иргэдийн оролцоотой “Шинэ сүм” төсөл хэрэгжүүлнэ.
- Иргэдийн санаачлагад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн зохистой менежментийн төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин туулгад бүрэн хамруулж эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг хэрэгжүүлнэ.
- Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Газар тариаланг урамшуулах бодлогыг шинэчилнэ.
- Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- Таримал ургамалын үр үржүүлгийн аж ахуйг цогцоор хөгжүүлэн царгас тариалалтыг нэмэгдүүлж уурагжуулсан малын тэжээл үйлдвэрлэх нөөцийг бүрдүүлнэ.
- Үр үйлдвэрлэгчдийн холбоог дэмжих замаар үрийн сорт сорилт, чанарыг сайжруулж уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон нутагшсан сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- Хүнсний ногоо, жимс жимсгэнэ агуулах зоорь, хөргүүрийн багтаамжийг нэмэгдүүлэх аж ахуйн нэгжид хөнгөлөлт үзүүлнэ.
- Тариалангийн уламжлалт бүс нутгууд дахь үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх замаар баруун бүс нутгийн гурилын хэрэгцээг хангана.
- Улаангом сумын газар тариалангийн бүс нутаг болон зарим сумдыг усны нөөц бүхий газар хөв цөөрөм байгуулах замаар усалгатай газар тариаланг өргөжүүлнэ.
- Тэс сумын 1,2,3 р багуудын нутаг дэвсгэрийн хадлан бэлчээрийн талбайг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх.

- Увс аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан , аймгийнхаа нэрийг тив дэлхийд алдаршуулсан төр , нийгэм , спорт урлагийн алдартнуудыг шагнаж урамшуулах “маршал Ю.Цэдэнбал” нэрэмжит аймгийн шагналыг бий болгоно.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- Баруунбүснутгийн төрийн албан хаагчдыг сургах сургалтыг нийж бүрэн төвийг Улаангом хотод байгуулна.
- Гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах үндэсний тогтолцоог аймгийн түвшинд хэрэгжүүлэх хяналтын тогтолцоог бий болгоно.
- Хууль, шүүхийн байгууллагын албан тушаалтны ёс зүй зан харилцаанд тавих олон нийтийн хяналтыг сайжруулна.
- Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтыг нь иргэний болгох чиглэлээр өөрчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, бие даасан байдлыг дээшлүүлж, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна,
- Ашиг сонирхолын зөрчлийн хуулийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч хэрэгжилтэнд иргэд хяналт тавьж мэдээлэх тогтолцоог бий болгоно.
- Хуулиар тогтоосон хугацаанд төрийн байгууллага иргэддээ хариу өгдөг тогтолцоог бүрдүүлж, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
- Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болгоно,
- Төрийн байгууллага улирал бүр үйл ажиллагаагаа иргэдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнүүлж олон нийтэд тайлагнадаг журам гаргаж мөрдөнө,
- Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх шударга өрсөлдөөнд тулгуурласан мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлнэ
- Төрийн байгууллагаас зарлаж буй тендер шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй болгоно
- Аж ахуйн нэгжид гэрээгээр ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх,
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын чадавхыг сайжруулах
- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох цогц арга хэмжээг авч төрийн байгууллагуудад шийдвэр гаргахдаа иргэний зөвлөл, ТББ-ын саналыг заавал авсан байх тогтолцоог бий болгоно,
- Төрийн албан хаагчдын урамшууллыг иргэний зөвлөл, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа дүгнэлтэнд үндэслэн тогтоодог болгоно

- Цахим орчинд хүний нэр төр,ажил хэргийн нэр хүндийг хамгаалах байгууллага,хувийн мэдээлэл,нууц өгөгдлийн аюулгүй байдлыг хангах аймгийн зөвлөлийг ажиллуулна.
- Аливаа төрлийн ялгаварлал,дарамт хүчирхийллийг ажлын байр,олон нийтийн бүх орчинд таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- ИТХ-ын үйл ажиллагаанд иргэд цахимаар оролцох боломжийг бүрдүүлэн гаргасан цахим санаачлага,иргэдийн гаргасан цахим гарын үсэг бүхий асуудлыг хурлаар хэлэлцдэг журам тогтооно.
- Авлига албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангана.
- Хууль сурталчлах таниулах ажлын чанарыг дээшлүүлж,олог нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай,үр дүнтэй хүргэж ажиллана.
- Төрийн алба зарсан 60 тэрбум,иргэдийн боломжийн хулгйлсан ЖДҮ,сүм хөгжүүлэх сангийн хулгайч ИТХ төлөөлөгчид,авлига сонирхолын зөрчилд орооцолдож хууль зөрчсөн албан тушаалтнуудад нам харгалзахгүй хуулийн хариуцлага хүлээлгэх ажлыг зохион байгуулна
- Иргэний асуулга асуух хуулийг хэрэгжүүлж ажиллана.
- Төсвийн зарцуулалт,төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг сайжруулна.
- Захиргааны ерөнхий хууль,Шилэн дансны хууль,нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоо ,хяналтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэнд лүн шинжилгээ хийж зохисгүй үр дагаварыг арилгах арга хэмжээ авч ажиллана.
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага,мэргэжлийн холбоод,хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.
- Татвар төрийн хяналт шалгалтыг иргэн хуулийн этгээдэд зөвлөх дэмжих чиглэлээр ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
- Цахим өргөдөл гомдлын” иргэний оролцоо” төвийг байгуулан ажиллана.
- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажлыг сайжруулна.
- Төрөөс зохион байгуулах аливаа төсөл тендерийн сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгоно.

ТАВ. АЮУЛГҮЙ , АМГАЛАН МОНГОЛ

- Хуурамч мэдээлэл дижитал халдлагатай тэмцэх, төр иргэнийхээ цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, иргэдийнхээ тэнцвэртэй бодитой мэдээлэл авах нөхцөлийг хангаж ажиллана.
- Иргэн бүрийн аюулгүй байдлыг хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийгэмд түгээх иргэдийн оролцоог дэмжинэ.
- Гадаад харилцааны нэгдмэл нэг цонхны бодлогоо хэрэгжүүлж ажиллана.
- Хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааг эрчимжүүлнэ.
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж ажиллах цагийг уртасгана.

- Усны хэрэглээ хяналт хэмнэлтийн бодлогыг бий болгож менежментийг сайжруулна.
- Бэлчээрийн ургамал сэргээх чадавхад суурилсан орон нутгийн менежментийг бий болгоно.
- Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Ой рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Агаарын чанарын хяналтын тогтолцоог бий болгож чанарыг сайжруулах хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан гадаадын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж импортоор орж ирэх техник технологид хөнгөлөлт үзүүлнэ.
- Шинээр баригдах барилга байгууламжуудад тавих ногоон байгууламжийн шаардлагыг дээшлүүлж байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх, төсвийн 10%-ийг ногоон байгууламжид зарцуулах
- Нөхөн сэргээдэггүй /Уул, уурхай, ус/-ээс бусад төрлийн нөөц баялаг ашигласаны төлбөр хураамжаас улс, орон нутгийн төсөв бүрдүүлдэг байдлыг халж, зөвхөн тухайн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, цаашид удаан хугацаанд тогтвортой ажилахад зарцуулах чиглэл баримтлах,
- Тусгай хамгаалалттай газрын ойн санд бэлтгэлийн ажил хийх нөхөрлөлүүдийг ойн мэргэжлийн байгууллага болгох замаар ой хамгаалах менежментийг сайжруулах
- Амьдарч ажиллаж байгаа орчиноо ногооруулж, цэцэрлэгжүүлж, тохижуулсан иргэн, ААН-г урамшуулах
- Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх



Баруунтуруун сум

Увс аймгийн Ардчилсан намын аймгийн мөрийн хөтөлбөрт сумдын нэр заасан хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээс гадна дараах үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмблэн үлсын болон орон нутгийн төсвөөр санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.



- Төрийн үйлчилгээний болон захиргааны барилга байгууламжийг засварлах, өргөтгөх, шинээр барина.
- Орон нутгийн чанартай авто зам, гүүр, даваа гүвээг засна.
- Сумын төвийн нэгдсэн халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, инженерийн шугам сүлжээг өргөтгөн орон сууцжуулна.
- Төрийн үйлчилгээний байгууллагуудын авто паркийг байгуулан дулаан гтаж бүхий засвар үйлчилгээний төвтэй болгоно.
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- Хөв цөөрөм байгуулах замаар мал аж ахуйн фермер, тэжээлийн ургамал, газар тариалан эрхлэх аж ахуйн үйл ажиллагааг дэмжинэ.
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх сүлжээ агуулахуудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Хүн амын суурьшил олонтой багийн төвүүдийг цахилгаан эрчим хүчинд холбоно.
- Малчдын аюулгүй байдлыг хангах, "нүүдэл" төвүүдийг нүүдлийн зам дагуу байгуулна.
- Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх урлаг спортын цогцолбор байгуулна.
- Ахмадын өдөр өнжүүлэх төвийг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.
- Сумын төвийн ногоон байгууламж, гэрэлтүүлгийг өргөтгөнө.
- Хил хамгаалах иргэдийн санал санаачилгыг дэмжихийн зэрэгцээ хилийн харуул заставын байрыг барьж байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран "Жаргалтай өрх" эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээний төв байгуулна.
- Сум хөгжүүлэх санг нэмэгдүүлж шаардлагатай бизнесийг дэмждэг нээлттэй ил тод тогтолцоог бүрдүүлнэ.
- Турууны гол дээр бетонон гүүр барих

Бөхмөрөн сум

Увс аймгийн Ардчилсан намын аймгийн мөрийн хөтөлбөрт сумдын нэр заасан хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээс гадна дараах үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмблэн улсын болон орон нутгийн төсвөөр санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.



- Төрийн үйлчилгээний болон захиргааны барилга байгууламжийг засварлах, өргөтгөх, шинээр барина.
- Орон нутгийн чанартай авто зам, гүүр, даваа гүвээг засна.
- Сумын төвийн нэгдсэн халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, инженерийн шугам сүлжээг өргөтгөн орон сууцжуулна.
- Төрийн үйлчилгээний байгууллагуудын авто паркийг байгуулан дулаан граж бүхий засвар үйлчилгээний төвтэй болгоно.
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- Хөв цөөрөм байгуулах замаар мал аж ахуйн фермер, тэжээлийн ургамал, газар тариалан эрхлэх аж ахуйн үйл ажиллагааг дэмжинэ.
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх сүлжээ агуулахуудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Хүн амын суурьшил олонтой багийн төвүүдийг цахилгаан эрчим хүчинд холбоно.
- Малчдын аюулгүй байдлыг хангах, "нүүдэл" төвүүдийг нүүдлийн зам дагуу байгуулна.
- Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх урлаг спортын цогцолбор байгуулна.
- Ахмадын өдөр өнжүүлэх төвийг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.
- Сумын төвийн ногоон байгууламж, гэрэлтүүлгийг өргөтгөнө.
- Хил хамгаалах иргэдийн санал санаачилгыг дэмжихийн зэрэгцээ хилийн харуул заставын байрыг барьж байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран "Жаргалтай өрх" эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээний төв байгуулна.
- Сум хөгжүүлэх санг нэмэгдүүлж шаардлагатай бизнесийг дэмждэг нээлттэй ил тод тогтолцоог бүрдүүлнэ.

Давст сум

Увс аймгийн Ардчилсан намын аймгийн мөрийн хөтөлбөрт сумдын нэр заасан хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээс гадна дараах үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмблэн улсын болон орон нутгийн төсвөөр санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.



- Төрийн үйлчилгээний болон захиргааны барилга байгууламжийг засварлах, өргөтгөх, шинээр барина.
- Орон нутгийн чанартай авто зам, гүүр, даваа гүвээг засна.
- Сумын төвийн нэгдсэн халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, инженерийн шугам сүлжээг өргөтгөн орон сууцжуулна.
- Төрийн үйлчилгээний байгууллагуудын авто паркийг байгуулан дулаан граж бүхий засвар үйлчилгээний төвтэй болгоно.
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- Хөв цөөрөм байгуулах замаар мал аж ахуйн фермер, тэжээлийн ургамал, газар тариалан эрхлэх аж ахуйн үйл ажиллагааг дэмжинэ.
